

“ХҮН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ” БАРИМТАТ БИЧВЭРИЙН УРАЛДААНД

“Дархан цаазат говийн багачуул”

Дархан цаазат газрын жолооч Т.Лхагвын том хүү Оргилболд энэ жил 8 дугаар ангид орно. Тэр аав, ээж, 2 дүүгийн хамтаар Тахийн тал хэмээх буйдхан багийн төвөөс холгүйхэн “Тахь” хэмээх жижиг сууринд амьдардаг. Түүний ухаан орохоос л эхлэн дархан газар, тахь, байгаль хамгаалал гэсэн үгнүүд хамгийн их сонсогддог байсан гэхэд болно. Түүний дүү Батзориг энэ жил 7 настай. Уг нь 2 дугаар ангийн сурагч болно гэж хөөрч байгаа хэдий ч өмнөх жилийн намар хальт суугаад өнгөрсөн сургууль, үзсэн цөөхөн үсгээ хөл хорио, хөгжөөнтэй зуны амралттайгаа нийлүүлээд бараг л мартсан. Ганц нэг үсэг үсэглээд таних төдий болжээ. Отгон дүү Санжаадамба хэлд орж амжаагүй ч хөлд ороод энүүгээр тэрүүгээр элдэв шавьж, гүрвэлтэй хөөцөлдөж, хөмүүл түүж, чулуу шидэж өдрийг өнгөрөөнө. Ахад багадаж дүүд шилжсэн улаан дугуйгаа унаж чадахгүй мөртлөө хаашаа ч явсан өдөрчин түрж, чирж гүйнэ. Ойр зуур хүмүүсийн заасан хэдэн үгийг тоть мэт давтаад бас хэлчихнэ.



Оргилболдын хувьд “Хөл хорио”, “корона”, “вакцин” “синофарм”, “дельта” гэх мэт үгнүүдийг энэ жил шинээр сурч авчээ. Гэхдээ энэ хэдхэн үг л түүний энэ зун олж авсан мэдлэг бишээ.

Дархан газарт хааяа ирдэг судлаачдыг даган хүүхэд насны сониуч зангаар тэдний үйл хөдлөл, хийж байгаа зүйлсийг ажиглан заримд нь тусалж заримыг нь даган дуурайж үзнэ. Энэ зун тус дархан газарт 2 нутагтан, мөлхөгч судлахаар төвөөс хүмүүс иржээ. Оргилболдын хувьд говь нутагт төрж, өссөн бусад хүүхдүүдийн нэгэн адил хонин гүрвэл, могой гүрвэлийг гарынхаа 10 хурууг нэрлэдэгээс илүү нэрлэчихнэ. “Замба зараа” гэдэг арзгар толгойтой, тохойн чинээ том гүрвэлийг аавтайгаа хамт явж байгаад Алаг нуурын хөвөөнөө нэг удаа харж байсан. Саяхан багийн төвийн шийдэн дээр сагс тоглож байхад айлын хүүхэд могой гээд урт нарийхан хорхой барьчихсан явахыг бас хальт хараад өнгөрсөн. Түүний хүйтэн цуст амьтны тухай мэдлэг ингэсхийгээд ер нь дөхнө.



Харин судалгаагаар ирсэн хүмүүсийг даган гүйж явахдаа гүрвэл, могой гэж амьтад чинь ямар олон янз, ямар сонирхолтой амьтад болох талаар олон зүйл сурч мэджээ. Гүрвэл могойг хэрхэн хайж олох, олсон зүйлээ таньж тодорхойлох, аюулгүй байдлаар бариж, цуглуулах, дээжинд авах гэх мэт олон шат дараатай ажлуудыг ажиглаж, харж, сурч авахыг эрмэлзэнэ. Мөн заримдаа тэднийг барихгүй хөөхгүй мөртлөө тоолох, нягтлах гээд замналаар алхана. Түүний төрөхөөс л мэддэг байсан дархан газарт нь нөгөө хуучин таньдаг 2 гүрвэлээс гадна монгол оронд ховор, нандинд тооцогдох толбот гүрвэл, төмөр гүрвэл, говийн гүрвэл гэх мэт гүрвэлүүд байхаас гадна тэмээн сүүл могой, нарийн могой, суман могой, рашааны могой, бамбай хоншоорт могой гэх мэт олон янзын могой байдгийг мэдэж авлаа. Төмөр гүрвэл гэх чигчий хурууны чинээ бараан саарал өнгөтэй, том нүдтэй, нүдний хүүхэн хараа нь босоо гүрвэлийг судлаачид хад чулуу сөхөөд олчихно тун сонин. Хээр хөдөө хаа сайгүй таарах хэвтээ тэр чулуун доор тийм сонин гүрвэл байна гэж тэр урьд нь мэдээгүй явжээ. Энэ гүрвэл нь шөнийн идэвхтэй бөгөөд жижиг дэнгийн цагаан эрвээхэй иддэг гэнэ. Мөн судлаач ах, эгч нар Алаг нуурын говь яваад ирэхдээ говийн гүрвэл гэх урт цоохор биетэй гүрвэл авчирч сонирхуулав. Өнгө алагласан эрээн цоохор зүс нь харц булаана. Гүрвэл ийм гоё өнгөтэй, өхөөрдөм амьтан гэж урьд нь тэр бодож явсангүй. Хөвчийн нуруу, Алаг нуур, Яглагийн хавцалаас барьж цуглуулсан замба зараанууд ч түүний сонирхолыг ихэд татлаа. Урьд нь нутгийн ах нар “замба зараа” олуулаа нийлбэл хүн барьдаг, цээжээрээ хад дэлдэн уурладаг гэх мэтийг сонсож, жаахан жийрхэн холоос харж байснаас биш дэргэдээс харж, аавынхаа хуучин гээд өөрт нь

шилжүүлсэн өөрийн “анхны” ухаалаг утсаараа зургийг нь авна гэж бодоогүй явжээ. Харин түүний дүү Батзориг бол харсан бүхнээ сонжиж, оролдож явдаг “өрөмний өт шиг” хөдөлгөөнтэй хүүхэд. Дэггүй Батзориг томчуулыг дуурайн гүрвэлтэй хөөцөлдөж явахдаа хонин гүрвэлийн сүүл таслаж, тасарсан сүүл могойг өнхөрөхийг харж зугаацаж байсныг Оргилболд хүү болиулж ахиж ингэж болохгүй гэж ахын ёсоор дүүдээ сургамжилан байгаа нь харагдана.



Оргилболд хүүхэд болсон хойно энэ бүгдийг чинхүү сонирхон, судлаачдын авчирсан номыг эргүүлж, зургийг үзэн, өөрөө том ах, эгч нар шигээ судлаач болоод говь нутагтаа ирж олон сонин содон гүрвэл, могой үзэж, шинээр олж нээн, тэдний амьдралыг судлаж байна гэж зүүдлэнэ.

Хүүхэд бүр эрэгтэй нь цагдаа, эмэгтэй нь эмч, багш болно гэж мөрөөддөг бол “дархан газрын багачуул” байгаль хамгаалагч, судлаач болно хэмээн мөрөөддөг. Тэдний мөрөөдөл гэнэн цагаахан хэдий ч биелэж болох сайхан мөрөөдөл.

Зуны дууслаа, сургууль удахгүй эхэлнэ. Оргилболд энэ зуныг мөлхөгч судлаж өнгөрүүлжээ. Одоо тэр үеийн нөхөддөө, хамт олондоо нутгийнхаа хэдэн гүрвэлийг заах хэмжээний мэдлэгтэй болжээ. Түүний дүү нар Батзориг, Санжаадамба 2 одоо гүрвэл сүүлдэж, айлгаж тоглож болохгүй гэдгийг мэддэг болсон. Түүний хувьд шинэ зүйл сурч мэдсэн “хөл хориотой” ч хөгжөөнтэй зун болж өнгөрлөө.



Зохиогч: Ёндон Г., Г.Довчиндорж

Зургийг Г. Ёндон

Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас баримтат бичвэрийн уралдааны гуравдугаар байрны шагналтан

“Хүн бүр байгаль хамгаалагч” сэдэвт баримтат бичвэрийн уралдаан
Энэхүү уралдаан нь иргэдийн байгаль орчны төлөөх үйлсийг урамшуулах, сурталчлах, мөн байгаль орчны асуудалд хүмүүсийг анхаарлыг татах, ялангуяа зуны амралтын үеэр илүү онцлох зорилготой байлаа.

2021 оны 8 -р сар